

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж

2.1.Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах үндэсний болон орон нутгийн зөвлөл, гамшгаас хамгаалах алба, төрийн болон нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэний оролцоог уялдуулан зохицуулах, гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх харилцаанд үйлчилнэ.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“гамшиг” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;

4.1.2.“аюулт үзэгдэл” гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, хортон шавьж, мэрэгч тархах зэргийг;

4.1.3.“осол” гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж, шугам сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох зэргийг;

4.1.4. “гамшгийн эрсдэл” гэж гамшгийн аюулын улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлалыг;

4.1.5. “гамшгийн аюул” гэж хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагааг;

4.1.6. “гамшгийн эмзэг байдал” гэж гамшгийн аюулд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчин зэрэг өртөхийг;

4.1.7. “гамшгаас хамгаалах үйл ажиллагаа” гэж гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхийг;

4.1.8. “гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа” гэж гамшгийн эрсдэлийг үнэлэх, болзошгүй хохирлыг багасгах, улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжил, олон нийтийн гамшгийг тэсвэрлэх, даван туулах чадавхийг сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээг;

4.1.9. “гамшгийн зарлан мэдээлэл” гэж гамшгийн аюулын дохио, сэрэмжлүүлэх мэдээллийг олон нийтэд хүргэхийг;

4.1.10. “эрэн хайх, аврах ажиллагаа” гэж гамшгийн аюулын үед хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн хайх, аврах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх арга хэмжээг;

4.1.11. “гамшгийн голомт” гэж гамшгийн аюулын улмаас хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт тогтоон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах ажиллагаа явуулж байгаа объект, нутаг дэвсгэрийг;

4.1.12. “сэжигтэй бүс” гэж хүн, мал, амьтны гоц халдварт өвчний голомтыг тодорхойлох зорилгоор хүн, мал, амьтанд үзлэг, оношилгоо хийх ажиллагаа явуулж байгаа нутаг дэвсгэрийг;

4.1.13. “нэрвэгдэгсэд” гэж гамшгийн аюулд өртсөн иргэдийг;

4.1.14. “гамшгийн үеийн дайчилгаа” гэж эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор нэмэлт хүч хэрэгслийг татан оролцуулах, шаардлагатай барилга байгууламж, газар ашиглахыг;

4.1.15. “гамшгийн хор уршиг” гэж гамшгийн аюулын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, мал, амьтан хорогдсон, эд хөрөнгө үрэгдсэн, хүрээлэн байгаа орчинд нөлөөлсөн үр дагаврыг;

4.1.16. “гамшгийн хор уршгийг арилгах” гэж 4.1.15-д заасан үр дагаврыг багасгах, хоёрдогч аюулын шинж чанарыг бууруулах, гамшгийг гэтлэн давахад чиглэсэн хойшлуулшгүй үйл ажиллагааг;

4.1.17. “сэргээн босгох ажиллагаа” гэж гамшгийн улмаас үүссэн нөхцөлийг хэвийн байдалд оруулахад чиглэсэн шинээр босгох, сэргээн засварлах арга хэмжээг;

4.1.18. “нийгмийн эмзэг бүлэг” гэж хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, өндөр настан, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг”.

5 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны чиглэл

5.1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа дараах чиглэлтэй байна:

5.1.1. гамшгаас хамгаалах үйл ажиллагааг мэргэжлийн нэгдсэн удирдлагаар хангах, зохицуулах;

5.1.2. гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагааг салбар дундын үйл ажиллагаатай уялдуулан улс, орон нутгийн эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийн төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх;

5.1.3. хүн амд гамшгаас хамгаалах боловсрол олгох, сургалт, сурталчилгааг тусгай хөтөлбөрийн дагуу шат дараатай зохион байгуулах;

5.1.4.гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшгийн болон орон нутгийн нөөц бүрдүүлэх, түүнийг нөхөн сэлбэх;

5.1.5.гамшгийг эрт илрүүлэх, сэрэмжлүүлэх, зарлан мэдээлэх;

5.1.6.гамшгийн үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх, хүч хэрэгсэл дайчлан гаргах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;

5.1.7.гамшгийн дараа сэргээн босгох, хүн амыг амьдралын хэвийн үйл ажиллагаанд оруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

6 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зарчим

6.1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

6.1.1.хүмүүнлэг, шуурхай, ил тод, хариуцлагатай байх;

6.1.2.мэргэжлийн нэгдмэл удирдлагатай байх;

6.1.3.шинжлэх ухаан, дэвшилтэт техник, технологи, инновацид тулгуурласан байх;

6.1.4.өмчийн хэлбэрийг үл харгалзах;

6.1.5.иргэдийн оролцоонд тулгуурлах;

6.1.6.жендерийн онцлог, нийгмийн эмзэг бүлгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

7 дугаар зүйл.Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

7.1.Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна:

7.1.1.гамшгийн эрсдэлийг үнэлэх;

7.1.2.гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх;

7.1.3.гамшгийн эрсдэлийг бууруулах;

7.1.4.гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах;

7.1.5.гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх;

7.1.6.гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааг зохион байгуулах;

7.1.7.гамшгийн болон эрсдэлийн мэдээллийн сан бүрдүүлэх, судалгаа, шинжилгээ хийх.

7.2.Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл нь гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагаа байна.

8 дугаар зүйл.Гамшгийн эрсдэлийг үнэлэх

8.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, хуулийн этгээд нь өмчийн хэлбэрийг үл харгалзан гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэнэ.

8.2.Гамшгийн эрсдэлийн үнэлгээг энэ хуулийн 8.3-т заасан тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ.

8.3.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах шаардлагыг хангасан хуулийн этгээдэд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгоно:

8.3.1.эрсдэлийн үнэлгээний багийн бүрэлдэхүүн нь тухайн чиглэлээр мэргэшсэн байх;

8.3.2.шаардлагатай судалгаа, шинжилгээний багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх;

8.3.3.гамшгийн эрсдэлийн үнэлгээнд шаардагдах мэдээ, баримт, өгөгдөл бүхий мэдээллийн сантай байх;

8.3.4.гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийх тогтсон арга, аргачлалтай байх.

8.4.Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журмыг Засгийн газар батална.

8.5.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гамшгийн эрсдэлийн үнэлгээний гүйцэтгэл, тайланд хяналт тавьж ажиллана.

8.6.Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардагдах зардлыг энэ хуулийн 8.1-д заасан байгууллага өөрөө хариуцна.

9 дүгээр зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх

9.1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, хуулийн этгээдэд өмчийн хэлбэр үл харгалзан төлөвлөж хэрэгжүүлнэ.

9.2.Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах удирдлагын баримт бичиг байна.

9.3.Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, аргачлалыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

10 дугаар зүйл.Гамшгийн эрсдэлийг бууруулах

10.1.Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор энэ хуулийн 9.1-д заасан байгууллага, хуулийн этгээд дараах арга хэмжээг авна:

10.1.1.болзошгүй гамшгийг үүсгэх эх үүсвэр, нөхцөл шалтгааныг арилгах;

10.1.2.барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн болон үйлдвэр үйлчилгээний газрын аюулгүй байдлын шаардлага, стандартыг хангах;

10.1.3.гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг хэрэгжүүлэх;

10.1.4.гамшигтай тэмцэх чадавхийг нэмэгдүүлэх;

10.1.5.хөгжлийн төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох.

11 дүгээр зүйл.Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах

11.1.Онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн алба, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, хуулийн этгээд нь гамшгаас хамгаалах бэлэн байдлын дараах зэрэгтэй байна:

11.1.1.өдөр тутмын бэлэн байдал;

11.1.2.өндөржүүлсэн бэлэн байдал;

11.1.3.бүх нийтийн бэлэн байдал.

11.2.Гамшгийн бэлэн байдлыг хангах шалгалт явуулах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

11.3.Өдөр тутмын бэлэн байдлын үед дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

11.3.1.нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах;

11.3.2.харилцаа холбоо, зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдлыг хангах, тогтоосон дохиогоор ажиллах арга, ажиллагаанд хүн амыг сургаж дадлагажуулах;

11.3.3.гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах;

11.3.4.гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний мэдээллийг түгээх;

11.3.5.гамшгийн нөөц бүрдүүлэх;

11.3.6.гамшгийн үеийн дайчилгаагаар ажиллах хүч хэрэгслийн бүртгэл, тооцоог гаргах.

11.4.Тодорхой нутаг дэвсгэр, объектод гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх бөгөөд өндөржүүлсэн бэлэн байдлын үед дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

11.4.1.гамшгийн зарлан мэдээллийн дохиог хүн амд хүргэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодотгол хийх;

11.4.2.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх. Ажлын тусгай горимоор ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно;

11.4.3.сэрэмжлүүлэх дохио, мэдээллийг хүн ам түүний дотор эмзэг бүлгийн иргэдэд тогтмол, цаг алдалгүй хүртээмжтэй хүргэх;

11.4.4.хорио цээрийн дэглэм тогтоох, хүн хүч, техник хэрэгсэл, гамшгаас хамгаалах нөөцийг дайчлах;

11.4.5.гамшгаас хамгаалах хүч хэрэгсэлтэй сургалт явуулах;

11.4.6.гамшгаас хамгаалах нөөцийг улсын хэмжээнд Засгийн газрын шийдвэрээр, орон нутагт тухайн шатны Засаг даргын шийдвэрээр нэмэгдүүлэх.

11.5.Харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага нь өндөржүүлсэн бэлэн байдлын үед гамшигтай холбоотой мэдээ, мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээн авч дамжуулна.

11.6.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжид үүссэн гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх бөгөөд бүх нийтийн бэлэн байдлын үед дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

11.6.1.харилцаа холбоо, эрчим хүч, нийтийн аж ахуйн үйлчилгээ, шатахуун түгээх газар болон стратегийн зориулалттайгаас бусад үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хязгаарлах;

11.6.2.гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх.

11.7.Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шууд шилжүүлсэн үед өндөржүүлсэн бэлэн байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээг нэгэн адил хэрэгжүүлнэ.

12 дугаар зүйл.Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх

12.1.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг шат дараатай зохион байгуулах, хэрэгжүүлэх зорилгоор энэ хуулийн 12.3-т заасан албан тушаалтан бэлэн байдлын удирдамжийн дагуу өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлнэ.

12.2.Бэлэн байдлын зэргийг тогтоохдоо засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, хуулийн этгээд, иргэдийг бүрэн эсхүл хэсэгчилсэн байдлаар, шат дараалж эсхүл шууд шилжүүлнэ.

12.3.Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэрийг дараах этгээд гаргана:

12.3.1.сум, дүүргийн нутаг дэвсгэрт, түүний зарим хэсэгт үүссэн буюу үүсч болзошгүй гамшгийн үед холбогдох мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн тухайн сум, дүүргийн Засаг дарга;

12.3.2.хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн нутаг дэвсгэрт үүссэн буюу үүсч болзошгүй гамшгийн үед холбогдох мэргэжлийн байгууллага болон тухайн сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга;

12.3.3.улсын хэмжээнд, эсхүл аймаг, нийслэл болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрт үүссэн буюу үүсч болзошгүй гамшгийн үед тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар.

12.3.4.гамшгаас хамгаалах улсын албаны дарга шаардлагатай тохиолдолд эрхэлсэн салбарыг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж болно.

12.4.Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэхээр энэ хуулийн 12.3-т заасан албан тушаалтны гаргасан саналд нутаг дэвсгэрээр дамжин тархсан, бүс нутгийг хамарсан, хамарч болзошгүй гамшгийн цагийн байдлын үнэлгээ, өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх үндэслэлийг тусгаж шийдвэрийн төслийг хавсаргана.

12.5.Шаардлагатай тохиолдолд гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд Зэвсэгт хүчний дэмжлэгийг авна.

12.6.Гамшгаас хамгаалах сургалтын үед нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн анги, байгууллага, хуулийн этгээдийг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт түр шилжүүлж болно.

12.7.Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэр гаргасан албан тушаалтан, эсхүл түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан бэлэн байдлын зэргийг бууруулах, цуцлах шийдвэрийг гаргана.

13 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх

13.1.Гамшгийн аюулын эх үүсвэрийг тодорхойлох, хязгаарлах, таслан зогсоох зорилгоор гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт, байгууллага, хуулийн этгээдийн гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр төлөвлөсөн хөрөнгө, түүний зарцуулалтад гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч хяналт тавина.

13.2.Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг Засгийн газар батална.

13.3.Гамшгаас хамгаалах улсын хяналтын ерөнхий байцаагч нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга байна.

14 дүгээр зүйл.Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааг зохион байгуулах

14.1.Гамшгаас хамгаалах сургалт нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд байгууллага, хуулийн этгээд, нутгийн захиргааны байгууллага, тэдгээрийн албан тушаалтан, ажилтан, иргэнийг сургаж дадлагажуулахад чиглэнэ.

14.2.Гамшгаас хамгаалах сургалтыг дараах ангиллаар явуулна:

- 14.2.1. удирдах албан тушаалтны;
- 14.2.2. онцгой байдлын байгууллага, мэргэжлийн ангийн;
- 14.2.3. оюутан, сурагч, сургуулийн өмнөх насны хүүхдийн;
- 14.2.4. байгууллага, хуулийн этгээдийн ажилтны;
- 14.2.5. иргэний.

14.3.Гамшгаас хамгаалах сургалтыг дараах байгууллага, албан тушаалтан зохион байгуулна:

14.3.1. онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтан, гамшгаас хамгаалах улсын алба, аймаг, нийслэлийн удирдах албан тушаалтны сургалтыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

14.3.2. аймаг, нийслэл, дүүргийн гамшгаас хамгаалах алба, сум, байгууллага, хуулийн этгээдийн мэргэжлийн ангийн удирдах албан тушаалтан, дүйцүүлэх албаны алба хаагчийн сургалтыг орон нутгийн онцгой байдлын байгууллага;

14.3.3. дүүргийн гамшгаас хамгаалах алба, сум, хорооны мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн сургалтыг тухайн шатны Засаг дарга, байгууллага, хуулийн этгээдийн мэргэжлийн анги, ажилтны сургалтыг тухайн байгууллага, хуулийн этгээдийн удирдлага;

14.3.4. иргэний сургалтыг тухайн баг, хорооны Засаг дарга;

14.3.5. онцгой байдлын байгууллагын алба хаагчийн сургалтыг тухайн байгууллага, анги, салбарын удирдлага;

14.3.6. оюутан, сурагч, сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалтыг батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу тухайн шатны боловсролын асуудал эрхэлсэн байгууллага.

14.4. Онцгой байдлын байгууллагын алба хаагч, мэргэжлийн анги, иргэн, байгууллага, хуулийн этгээдийн ажилтны сургалтыг жил бүр, гамшгаас хамгаалах албаны удирдах албан тушаалтны сургалтыг 2 жилд нэг удаа зохион байгуулна.

15 дугаар зүйл.Гамшгийн болон эрсдэлийн мэдээллийн сан бүрдүүлэх, судалгаа, шинжилгээ хийх

15.1.Тохиолдсон гамшгийн аюул, гамшгийн дүн мэдээг нэгтгэх, статистик тоо баримтыг боловсруулах, гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээ хийх, үр дүн, санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа ашиглах, мэдээлэх, нийтийн хүртээл болгох, гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

15.2.Гамшгийн болон эрсдэлийн бүртгэл, мэдээллийн санд дараах мэдээллээс бүрдэнэ:

15.2.1.гамшгийн эрсдэлтэй нутаг дэвсгэрийн газар зүйн мэдээлэл;

15.2.2.гамшгийн эрсдэлд нэрвэгдэж болзошгүй хүн ам, барилга, байгууламж, эд хөрөнгийн бүртгэл, мэдээлэл;

15.2.3.гамшгийн хор уршигтай холбоотой эдийн засгийн дүн мэдээ;

15.2.4.онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГАМШГИЙН ҮЕИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

16 дугаар зүйл.Гамшгийн үеийн үйл ажиллагаа

16.1.Гамшгийн үеийн үйл ажиллагаа нь дараах үйл ажиллагаанаас бүрдэнэ:

16.1.1.гамшгийн зарлан мэдээлэл, харилцаа холбоог зохион байгуулах;

16.1.2.голомтын бүсийг тогтоох;

16.1.3.эрэн хайх, аврах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх;

16.1.4.хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх;

16.1.5.гамшгийн хор уршгийг арилгах.

16.2.Гамшгийн үеийн үйл ажиллагааг холбогдох дүрэм, журам, заавар, стандартын дагуу зохион байгуулна.

16.3.Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

17 дугаар зүйл.Гамшгийн зарлан мэдээлэл, харилцаа холбоог зохион байгуулах

17.1.Гамшгийн аюулын дохио, сэрэмжлүүлэг, гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг мэдээлэх зорилгоор зарлан мэдээллийг шуурхай зохион байгуулна.

17.2.Гамшгийн аюулын тухай мэдээ, мэдээллийг цуглуулах, удирдлагын шийдвэрийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад хүргэх, түүнчлэн улс хооронд харилцан мэдээлэл солилцоход бүх төрлийн харилцаа холбооны сүлжээг ашиглана.

17.3.Гамшгийн аюулын дохио, сэрэмжлүүлгийг харилцаа холбоо, хэвлэл, мэдээллийн байгууллага өмчийн хэлбэрээс үл хамааран шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах үүрэгтэй.

17.4.Гамшгийн голомтод ажиллаж байгаа шуурхай бүлэгтэй холбоо зохион байгуулах, мэдээлэл солилцох ажиллагааг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.

17.5.Гамшгийн зарлан мэдээлэл, түүнийг дамжуулах журмыг Засгийн газар батална.

18 дугаар зүйл.Гамшгийн голомтын бүс тогтоох

18.1.Гамшгийн голомтын бүсийг доор дурдсан албан тушаалтан тогтооно:

18.1.1.аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэрт тохиолдсон гамшгийн голомтын бүсийг мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга;

18.1.2.хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэр болон улсын онц чухал объектод тохиолдсон гамшгийн голомтын бүсийг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар.

19 дүгээр зүйл.Эрэн хайх, аврах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх

19.1.Гамшгийн голомтод эрэн хайх, аврах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх ажиллагааг шуурхай бүлэг гүйцэтгэнэ. Шуурхай бүлэг нь шаардлагатай техник, тоног төхөөрөмж, эрэлч нохой, тусгай зориулалтын хувцас, хэрэгслээр хангагдана.

19.2.Шуурхай бүлгийн удирдагч нь онцгой байдлын байгууллагын алба хаагч байх ба эрэн хайх, аврах ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэгтэй.

19.3.Эрэн хайх, аврах ажиллагаанд оролцож буй сайн дурын хэсэг, иргэн нь шуурхай бүлгийн удирдагчийн зааврын дагуу үүрэг гүйцэтгэнэ.

19.4.Нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламжийг эмнэлгийн байгууллага өмчийн хэлбэр, харъяаллаас үл хамааран шуурхай үзүүлэх үүрэгтэй.

20 дугаар зүйл.Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх

20.1.Гамшгийн аюулын үед шаардлагатай тохиолдолд хүч хэрэгслийг дайчлан гаргаж, хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйлийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлнэ.

20.2.Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх журмыг Засгийн газар батална.

21 дүгээр зүйл.Гамшгийн хор уршгийг арилгах

21.1.Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг гамшгийн нөхцөл байдлыг харгалзан нутгийн захиргааны байгууллага, байгууллага, хуулийн этгээд өөрөө, эсхүл гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээнд тулгуурлан төв, орон нутгийн онцгой байдлын байгууллага гүйцэтгэнэ.

21.2.Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээг Гамшгаас хамгаалах үндэсний зөвлөл чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон гамшгаас хамгаалах улсын алба хамтран гүйцэтгэнэ.

21.3.Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журмыг Засгийн газар батална.

21.4.Гамшгийн хор уршгийг арилгах ажиллагааг гүйцэтгэсэн хуулийн этгээдэд зардлын нөхөх олговор олгох, нэрвэгдэгсдэд дэмжлэг үзүүлэх асуудлыг Засгийн газрын баталсан журам болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ СЭРГЭЭН БОСГОХ АЖИЛЛАГАА

22 дугаар зүйл.Сэргээн босгох ажиллагаа

22.1.Сэргээн босгох ажиллагаа дараах чиглэлтэй байна:

- 22.1.1.нийгмийн үйлчилгээг хэвийн нөхцөлд оруулах;
- 22.1.2.дэд бүтцийг сэргээн босгох.

22.2.Сэргээн босгох ажиллагаанд шаардагдах зардлыг Гамшгаас хамгаалах үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

22.3.Шаардлагатай бол сэргээн босгох ажиллагаанд дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг авна.

22.4.Нийгмийн үйлчилгээ, дэд бүтцийг сэргээн босгох урт хугацааны үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ улс, орон нутгийн хөгжлийн бодлого, зорилттой уялдуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, УДИРДЛАГА

23 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт

23.1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, хуулийн этгээд өмчийн хэлбэр үл харгалзан зохион байгуулна.

23.2.Улсын хэмжээнд Гамшгаас хамгаалах үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд гамшгаас хамгаалах орон нутгийн зөвлөлийг байгуулна. Зөвлөл нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, бодлогын санал зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус байгууллага байна.

23.3.Гамшгийн хамгаалах үйл ажиллагааг тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, бүс хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, үүссэн цагийн байдалтай холбогдуулан хэрэгжүүлж байгаа арга хэмжээг уялдуулан зохицуулах, хяналт тавих зорилгоор онцгой комиссыг байгуулна.

23.4.Онцгой байдлын байгууллага нь улсын болон орон нутгийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага болон хуулийн этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.

23.5.Төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны нутгийн захиргааны байгууллага нь гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангитай байна. Сумын нутгийн захиргааны байгууллага нь гамшгаас хамгаалах чиг үүргийг гүйцэтгэх орон тооны ажилтантай байна.

23.6.Үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, үйл ажиллагааны цар хүрээ, ажиллагсдын тооноос хамааран зарим хуулийн этгээдэд мэргэжлийн анги байгуулах шаардлагыг энэ хуулийн 23.9-т заасан дүрмээр тогтоож болно.

23.7.Сум, баг, хороонд нутгийн иргэдэд түшиглэн гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг байгуулж болно. Сайн дурын хэсэг байгуулахтай холбогдсон харилцааг энэ хуулийн 37 дугаар зүйлээр зохицуулна.

23.8.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх анхан шатны нэгж нь баг, хороо, байгууллага, хуулийн этгээд байна.

23.9.Гамшгаас хамгаалах үндэсний болон орон нутгийн зөвлөл, онцгой комиссын ажиллах журмыг Засгийн газар, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дүрмийг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

24 дүгээр зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага

24.1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга удирдан зохион байгуулж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн шатны Засаг дарга, байгууллага, хуулийн этгээдэд тухайн байгууллага, хуулийн этгээдийн удирдлага зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

24.2.Гамшгаас хамгаалах үндэсний болон орон нутгийн зөвлөл нь гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлаар санал, дүгнэлт, бодлогын зөвлөмж гаргах, дүн шинжилгээ хийх, хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг уялдуулан тусгах, холбогдох талууд, салбар хоорондын түншлэл, хамтын ажиллагааг зохицуулах, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах санал боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

24.3.Гамшгаас хамгаалах үндэсний зөвлөлийг Ерөнхий сайд, аймаг, нийслэл, дүүргийн гамшгаас хамгаалах орон нутгийн зөвлөлийг тухайн шатны Засаг дарга тэргүүлнэ.

24.4.Улсын онцгой комиссыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн онцгой комиссыг Засаг дарга тэргүүлнэ. Улсын онцгой комиссын орлогч дарга нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, орон нутгийн онцгой комиссын орлогч дарга нь орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга, сумын онцгой комиссын орлогч дарга нь сумын Засаг даргын тамгын газрын дарга байна.

24.5.Гамшгаас хамгаалах улсын албыг холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагыг түшиглэн Засгийн газар, аймаг, нийслэл, дүүргийн гамшгаас хамгаалах албыг холбогдох төрийн захиргааны байгууллага түшиглэн тухайн шатны Засаг дарга, гамшгаас хамгаалах албыг түшиглэн мэргэжлийн ангийг сум, дүүрэг, хорооны Засаг дарга тус тус байгуулна.

25 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл

25.1.Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл нь онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагч, техник хэрэгсэл, эрэлч нохой, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа болон хаасан иргэн, гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, тэдгээрийн техник хэрэгсэл байна.

25.2.Мэргэжлийн ангийг Монгол Улсын харъяат, хөдөлмөрийн чадвартай, 18-60 хүртэлх насны эрэгтэй, 18-55 хүртэлх насны эмэгтэй иргэнээр бүрдүүлэх бөгөөд үүнд цэргийн алба хаагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, сургуулийн өмнөх насны хүүхэдтэй болон жирэмсэн эмэгтэй, ганц бие эцэг, эх хамаарахгүй.

25.3.Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох сайн дурынхан нь гамшгаас хамгаалах сургалт, дадлагад хамрагдсан байна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ БҮРЭН ЭРХ

26 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

26.1.Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй гамшиг тохиолдсон үед Улсын Их Хурал уг асуудлыг дараалал харгалзахгүйгээр хэлэлцэж Засгийн газарт чиглэл өгнө.

27 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

27.1.Засгийн газар гамшгаас хамгаалах асуудлаар хууль тогтоомжид зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

27.1.1.онцгой байдлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний танилцуулснаар Монгол Улсын гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогыг батлах;

27.1.2.гамшгаас хамгаалах төлөвлөгөө, гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, гамшгийн зэрэглэл тогтоох журмыг батлах;

27.1.3.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зэвсэгт хүчний анги, салбарыг оролцуулах шийдвэрийг зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр гаргах;

27.1.4.олон улсын хүмүүнлэгийн үйл ажиллагаанд аврах багийг оролцуулах шийдвэр гаргах;

27.1.5.гамшгийн аюулын түвшин, нөхцөл байдлын талаар нийтэд зарлан мэдээлэх.

28 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн бүрэн эрх

28.1.Гамшгаас хамгаалах үндэсний зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.1.1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийн бодлого, хөтөлбөр, үндсэн чиглэлд гамшгийн эрсдэлийг бууруулах стратегийн зорилт болон шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тусгуулах талаар мэргэжлийн санал, дүгнэлт, бодлогын зөвлөмж боловсруулах;

28.1.2.гамшгийн дараах сэргээн босгох арга хэмжээг оновчтой хэрэгжүүлэх, улс орны тогтвортой хөгжлийн бодлого, зорилтод уялдуулах бодлогын санал, зөвлөмж боловсруулах;

28.1.3.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд түншлэл, хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, санаачилгыг дэмжих;

28.1.4.гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, техник, технологийн шинэ ололт, инновацийг нэвтрүүлэх талаар чиглэл өгөх, шаардагдах хөрөнгийг холбогдох төсөвт суулгах санал боловсруулах;

28.1.5.гамшгаас хамгаалах орон нутгийн зөвлөлийг холбогдох бодлого, зөвлөмжөөр хангах;

28.1.6.гамшгийн эрсдэлийг бууруулах хөрөнгийн санг энэ хуулийн 53 дугаар зүйлд заасан эх үүсвэрээс бүрдүүлэх.

28.2.Гамшгаас хамгаалах орон нутгийн зөвлөл энэ хуулийн 28.1-д заасан бүрэн эрхээс өөрийн эрхэд хамаарах хэсгийг хэрэгжүүлнэ.

29 дүгээр зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

29.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гамшгаас хамгаалах асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

29.1.1.Монгол Улсын гамшгаас хамгаалах төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан чиглүүлэх;

29.1.2.улсын хэмжээнд, эсхүл аймаг, нийслэл болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрт үүссэн буюу үүсч болзошгүй гамшгийн үед өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зэвсэгт хүчний анги, салбарыг татан оролцуулах саналыг Засгийн газарт танилцуулах;

29.1.3.гамшгаас хамгаалах нөөцийг зохих журмын дагуу захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэлтэд хяналт тавих;

29.1.4.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах нэмэлт зардлыг Засгийн газрын нөөц хөрөнгөөс, бараа, материал, тоног төхөөрөмжийг улсын нөөцөөс гаргах асуудлыг Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;

29.1.5.гамшгаас хамгаалах хөтөлбөр, болон энэ хуульд заасан дүрэм, журам, заавар, удирдамжийг батлах;

29.1.6.гамшгийн нөхцөл байдлын талаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдад шуурхай мэдээлэх;

29.1.7.олон улсын эрэн хайх, аврах үйл ажиллагаанд аврах багийг оролцуулах саналыг Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;

29.1.8.онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох бодлого боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

29.1.9.онцгой байдлын байгууллагын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Засгийн газарт танилцуулах;

29.1.10.шаардлагатай тусгай барилга байгууламж, тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг шинэчлэн сайжруулах саналыг Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлэх.

30 дугаар зүйл.Онцгой байдлын байгууллагын бүрэн эрх

30.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.1.1.Монгол Улсын гамшгаас хамгаалах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газар болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах, хяналт тавих;

30.1.2.Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

30.1.3.гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх бэлэн байдлын удирдамжийг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх;

30.1.5.гамшиг, осол тохиолдсон болон гамшгийн аюулын нөхцөл байдлын талаар хүн амд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан эсхүл шууд мэдээлэх, заавар зөвлөмжөөр хангах;

30.1.6.шаардлагатай мэдээлэл, судалгааг гаргаж, гамшгийн цагийн байдлыг нэгтгэн дүгнэж онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулах;

30.1.7.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хүч хэрэгслийг дайчлан оролцуулах;

30.1.8.дайчилгаа, нүүлгэн шилжүүлэхэд гарсан зардлын нөхөн төлбөрийн талаар санал боловсруулан холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх;

30.1.9.Засгийн газраас олгосон бараа, материал, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг шаардлагатай газарт хүргэх, тээвэрлэх, хуваарилах ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

30.1.10.гамшгаас хамгаалах улсын алба, байгууллага, хуулийн этгээд, мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

30.1.11.гамшгийн нөөц бүрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, нөхөн сэлбэх;

30.1.12.гамшгийн болон эрсдэлийн мэдээллийн сан байгуулах, үйл ажиллагаандаа ашиглах;

30.1.13.гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбогдсон дүрэм журмыг боловсруулах;

30.1.14.гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, цуцлах, хяналт тавих;

30.1.15.гамшгаас хамгаалах талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

30.1.16.гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж нэгтгэн, түүнийг боловсронгуй болгох саналыг эрх бүхий байгууллагад танилцуулах;

30.1.17.гамшгаас хамгаалах асуудлаар бусад улс орон, олон улсын болон гадаад, дотоодын байгууллагатай харилцах, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

30.1.18.олон улсын эрэн хайх аврах ажиллагаанд оролцох багийг бүрдүүлж, чадавхжуулах ажлыг зохион байгуулах.

30.2.Орон нутгийн онцгой байдлын байгууллага нь энэ хуулийн 30.1-д заасан бүрэн эрхээс өөрийн эрхэд хамаарах хэсгийг хэрэгжүүлнэ.

31 дүгээр зүйл.Онцгой байдлын байгууллагын даргын бүрэн эрх

31.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

31.1.1.хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол гамшгаас хамгаалах албаны гүйцэтгэх үүргийг тодорхойлж, мэргэжлийн удирдлагаар хангах;

31.1.2.гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд шаардагдах хүч хэрэгслийг дайчлан оролцуулах;

31.1.3.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хүн амыг сургаж бэлтгэх;

31.1.4.гамшгаас хамгаалах үйл ажиллагаа болон онцгой байдлын байгууллагад дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг баталж мөрдүүлэх;

31.1.5.гамшгаас хамгаалах бэлэн байдлын удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавих;

31.1.6.гамшгийн нөхцөл байдлын талаар онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд шуурхай мэдээлэх;

31.1.7.гамшгаас хамгаалах харилцан ажиллагааны төлөвлөгөөг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран батлах;

31.1.8.онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах;

31.1.9.шаардлагатай тусгай барилга байгууламж, тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бусад хангамжийн бодлогыг боловсруулж, онцгой байдлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнд танилцуулах;

31.1.10.хүний нөөцийн хөгжлийг хангах, сургаж бэлтгэх;

31.1.11.онцгой байдлын байгууллагыг төлөөлж гадаад, дотоодын байгууллагатай харилцах;

31.1.12.онцгой байдлын байгууллагыг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, цуцлах шийдвэр гаргах;

31.1.13.алба хаагч, ажилтны аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

31.1.14.онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын газар, хэлтэс, харьяа нэгжийн удирдлага болон бусад ажилтныг томилох, чөлөөлөх, цол олгох, бууруулах, хураах.

31.2.Орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга энэ хуулийн 31.1-д заасан бүрэн эрхээс өөрийн эрхэд хамаарах хэсгийг хэрэгжүүлнэ.

31.3.Орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргана.

32 дугаар зүйл.Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

32.1.Нутгийн өөрөө удирдах байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.1.1.аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөр, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг баталж, гүйцэтгэлд хяналт тавих;

32.1.2.гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх Засаг даргын мэдээллийг сонсох, тайланг хэлэлцэх, чиглэл өгөх;

32.1.3.гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг санхүүжүүлэх сан байгуулах шийдвэр гаргах.

33 дугаар зүйл.Засаг даргын бүрэн эрх

33.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга гамшгаас хамгаалах асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

33.1.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх;

33.1.2.нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах алба, штаб, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг байгуулж, тэдгээрийг гамшгийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох;

33.1.3.гамшгийн үед шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, түүнийг захиран зарцуулах;

33.1.4.гамшгийн цагийн байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар дээд шатны болон онцгой байдлын байгууллагад мэдээлэх, тэднээс мэргэжлийн зөвлөгөө, зааварчилгаа, дэмжлэг авах;

33.1.5.иргэдэд гамшгаас хамгаалах мэдлэг, боловсрол олгох, нийгмийн эмзэг бүлгийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

33.1.6.нэрвэгдэгсдэд санхүүгийн болон эд материал, сэтгэл зүйн тусламж, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

33.1.7.гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, иргэдэд түшиглэсэн гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг дэмжих;

33.1.8.гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

33.1.9.гамшгийн үед нутаг дэвсгэрийн хэмжээнд хүч хэрэгслийг дайчлан оролцуулах;

33.1.10.орон нутгийн онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг ажиллах нөхцөл, боломжоор хангах;

33.1.11.харилцаа холбоо, зарлан мэдээлэх системийг байнгын бэлэн байдлыг хангах;

33.1.12.гамшгийн эрсдэлийн болон гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийлгэн, холбогдох арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх.

33.2.Баг, хорооны Засаг дарга энэ хуулийн 33.1-д заасан бүрэн эрхээс өөрийн эрхэд хамаарах хэсгийг хэрэгжүүлнэ.

34 дүгээр зүйл.Гамшгаас хамгаалах албаны нийтлэг чиг үүрэг

34.1.Гамшгаас хамгаалах улсын алба дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:

34.1.1.эрхэлсэн салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

34.1.2.салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох, бууруулах арга хэмжээг тусгах, хэрэгжүүлэх;

34.1.3.гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дээд шатны байгууллагын гамшгаас хамгаалах талаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах;

34.1.4.салбарын онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах албаны удирдлага, штаб, мэргэжлийн ангийг байгуулах, тэдгээрийн сургалт, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах;

34.1.5.гамшгийн үед эрхэлсэн салбарын тогтвортой ажиллагааг хангах;

34.1.6.эрхэлсэн салбарын зарлан мэдээллийн системийг байнгын бэлэн байдалд байлгах;

34.1.7.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулах хүч хэрэгсэл, шаардагдах нөөцийг бүрдүүлэх, бэлэн байлгах;

34.1.8.аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах албыг тухайн чиглэлийн мэргэжлийн удирдлагаар хангах;

34.1.9.гамшгийн нөхцөл байдлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шуурхай мэдээлэх, хамтран ажиллах;

34.1.10.гамшгийн голомтод ажиллах шуурхай бүлгийн бүрэлдэхүүнд ажиллах мэргэжлийн хүмүүсийг шаардагдах техник, материал, хэрэгслийн хамт оролцуулах;

34.1.11.гамшигтай холбогдуулж хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах;

34.1.12.гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийлгэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах;

34.1.13.гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа болон гамшгийн нөхцөл байдлын тухай мэдээ, тайлан гаргах.

34.2.Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

34.3.Гамшгаас хамгаалах улсын алба нь гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны албан хаагчтай байна. Албан хаагчийг онцгой байдлын төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөж томилно.

34.4.Аймаг, нийслэл, дүүргийн гамшгаас хамгаалах алба энэ хуулийн 34.1-д заасан чиг үүргээс өөрийн эрхэд хамаарах хэсгийг хэрэгжүүлнэ.

34.5.Аймаг, нийслэл, дүүргийн гамшгаас хамгаалах албаны ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

ДОЛООДУГААР БҮЛЭГ БАЙГУУЛЛАГА, ХУУЛИЙН ЭТГЭЭД, ИРГЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

35 дугаар зүйл. Байгууллага, хуулийн этгээдийн эрх, үүрэг

35.1.Байгууллага, хуулийн этгээд нь харьяалал, өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран гамшгаас хамгаалах талаар дараах эрх эдэлнэ:

35.1.1.гамшгаас хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар үнэн зөв, бодит мэдээлэл авах;

35.1.2.гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, зөвөлгөө авах.

35.2.Байгууллага, хуулийн этгээд нь харьяалал, өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран гамшгаас хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ:

35.2.1.гамшгаас хамгаалах төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх;

35.2.2.гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

35.2.3.үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах штаб, мэргэжлийн анги байгуулах, шаардагдах техник, материал, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах;

35.2.4.мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн болон ажилтныг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах;

35.2.5.гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, даатгалд хамрагдах;

35.2.6.гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэх, зориулалтын дагуу захиран зарцуулах;

35.2.7.гамшгаас хамгаалах үйл ажиллагаа болон гамшгийн аюулын нөхцөл байдлын тухай холбогдох мэдээг дээд шатны байгууллага болон онцгой байдлын байгууллагад цаг тухайд нь хүргэх, шаардлагатай баримт материал, бодит мэдээллээр хангах;

35.2.8.гамшгийн үед өөрийн байгууллагын хэрэгцээнд ашиглах байгууламж, хоргодох байрыг төхөөрөмжлөх, гамшгийн үед шаардлагатай тохиолдолд хүн амд ашиглуулах;

35.2.9.гамшгийн үед бараа, үйлчилгээний үнийн хөөрөгдөл болон зохиомол хомсдол үүсгэхгүй байх.

36 дугаар зүйл.Төрийн бус байгууллагын эрх, үүрэг

36.1.Төрийн бус байгууллага нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дараахь эрх, үүрэгтэй оролцоно:

36.1.1.гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн биелэлтэд иргэний хяналт тавих;

36.1.2.гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хууль тогтоомж, зөвлөмж, арга зүй боловсруулахад оролцох;

36.1.3.гамшгаас хамгаалах судалгаа, сургалт, сурталчилгааг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

36.1.4.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэн, сайн дурынхан, бүлэг, нөхөрлөл, нийгмийн эмзэг бүлгийн оролцоог идэвхжүүлэхэд дэмжлэг, тусламж үзүүлэх;

36.1.5.гамшгаас хамгаалах үйл ажиллагааг онцгой байдлын байгууллагатай байгуулсан гэрээ, санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх.

37 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, түүний эрх, үүрэг

37.1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох сайн дурынхан дараах эрх эдэлнэ:

37.1.1.гамшгаас хамгаалах сургалтад хамрагдах;

37.1.2.гамшгийн үеийн үйл ажиллагаанд оролцохдоо шаардагдах багаж, хэрэгсэл, хүнсээр хангагдах;

37.1.3.онцгой байдлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зардал, урамшуулал авах;

37.1.4.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох үед хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон, амь насаа алдсан тохиолдолд сайн дурын ажилтанд болон түүний гэр бүлд онцгой байдлын байгууллагын алба хаагчийн нэгэн адилаар тэтгэмж авах.

37.2.Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох сайн дурын хэсэг дараах үүрэг хүлээнэ:

37.2.1.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох, гамшгаас хамгаалах асуудлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг биелүүлэх;

37.2.2.гамшгийн нөхцөл байдлын талаар холбогдох байгууллагад үнэн зөв, бодит, шуурхай мэдээлэл өгөх;

37.2.3.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд аюулгүй байдлаа хангаж, шуурхай, үр дүнтэй оролцох.

37.3.Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох сайн дурын хэсэг байгуулах хүсэлтийг тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ.

37.4.Сайн дурын хэсэг нь Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу зохион байгуулагдана.

37.5.Сайн дурын хэсэг нь тухайн шатны Засаг даргад гамшгаас хамгаалах чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагаагаа тайлагнана.

37.6.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн үйл ажиллагаа явуулах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

38 дугаар зүйл.Иргэний эрх, үүрэг

38.1.Иргэн гамшгаас хамгаалах талаар дараах эрх эдэлнэ:

38.1.1.холбогдох байгууллага, албан тушаалтнаас өөрийн аюулгүй байдлаа хангахад шаардлагатай арга хэмжээний талаар үнэн зөв мэдээлэл авах;

38.1.2.гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг байгуулах, гишүүнээр элсэх, гамшгаас хамгаалах дундын хөрөнгийн сан үүсгэх;

38.1.3.нийгмийн эмзэг бүлгийн иргэд өөрсдийн онцлогт нийцсэн нөхцлийг шаардах;

38.1.4.нэрвэгдэгсэд амьдралын суурь хэрэгцээгээ хангахад шаардлагатай тусламж, дэмжлэг авах;

38.1.5.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох үед хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон, амь насаа алдсан иргэнд болон түүний гэр бүлд онцгой байдлын байгууллагын алба хаагчийн нэгэн адилаар тэтгэмж авах.

38.1.6.Гамшгийн голомт болон сэжигтэй бүсэд үндсэн ажлаас чөлөөлөгдөн үүрэг гүйцэтгэсэн бол цалин хөлсөө ажил олгогч байгууллагаас авах, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн тухайн шатны Засаг даргын шийдвэрээр нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний олговрыг авах.

38.2.Иргэн гамшгаас хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

38.2.1.гамшгаас хамгаалах хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхээр эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг биелүүлэх;

38.2.2.гамшгаас хамгаалах сургалт, зохион байгуулалттай бусад арга хэмжээнд оролцох;

38.2.3.ахуй амьдрал, өдөр тутмын үйл ажиллагаандаа аюулгүй байдлыг хангах, үйлдвэрлэлийн норм, стандарт, технологийг сахих, экологийн аюулгүй байдлын шаардлагыг зөрчихгүй байж, эрсдэлийг бууруулах;

38.2.4.өөрийгөө болон бусдыг гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах арга, техникийг эзэмших, зарлан мэдээлэх дохиогоор ажиллах журмыг дагаж мөрдөх;

38.2.5.гамшгийн аюулаас хамгаалах зориулалттай нийтийн болон нэг бүрийн хамгаалах хэрэгслийг ашиглаж сурах;

38.2.6.гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд тогтоосон журмын дагуу оролцох;

38.2.7.гамшгийн аюулын тухай мэдээллийг холбогдох байгууллагад шуурхай, үнэн зөв хүргэх;

38.2.8.эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг зөрчиж, өөрийн аюулгүй байдлаа хангаагүйн улмаас мэргэжлийн байгууллагын туслалцаа авсан тохиолдолд гарсан зардлыг хариуцах.

НАЙМДУГААР БҮЛЭГ ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ

39 дүгээр зүйл.Дотоодын хүмүүнлэгийн тусламж

39.1.Гамшгийн үйл ажиллагаанд үзүүлэх дотоодын хүмүүнлэгийн тусламжийг Засгийн газраас баталсан журмын дагуу зохицуулна.

40 дүгээр зүйл.Олон улсын хүмүүнлэгийн тусламж

40.1.Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээгээр гамшгийн хор уршиг, хохирол үндэсний эдийн засаг, нийгмийн нөөц боломж, чадавхаас давсан тохиолдолд Гамшгаас хамгаалах үндэсний зөвлөл, олон улсын хүмүүнлэгийн тусламж авах үндэслэл, саналыг Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлнэ.

40.2.Олон улсын хүмүүнлэгийн тусламж үзүүлэгч тал /цаашид “тусламж үзүүлэгч тал” гэх/ өөрийн дипломат төлөөлөгчийн байгууллагаар дамжуулан гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүмүүнлэгийн тусламж үзүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд Засгийн газар уг тусламжийг авах эсэх талаар шийдвэр гаргана.

40.3.Тусламж үзүүлэгч тал нь тухайн улсын болон олон улсын байгууллагад бүртгүүлсэн байна.

40.4.Монгол Улсаас гадаад улсад хүмүүнлэгийн тусламж үзүүлэхтэй холбогдсон харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

41 дүгээр зүйл.Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт

41.1.Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг зөв зохистой хуваарилах, хүмүүнлэгийн баг болон сайн дурын ажилтны үйл ажиллагааг зохицуулах үүргийг Гамшгаас хамгаалах үндэсний зөвлөл чиглүүлж, улсын онцгой комисс зохицуулна.

41.2.Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг Монгол Улсын хил, гаалиар нэвтрүүлэх журмыг Засгийн газар батална.

41.3.Засгийн газар тусламж үзүүлэгч талыг хэрэгцээт талбай болон байраар хангахыг нутгийн захиргааны байгууллагад үүрэг болгоно.

41.4.Тусламж үзүүлэгч талын үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр төрийн захиргааны болон олон улсын байгууллагын төлөөллөөс бүрдсэн хүмүүнлэгийн багийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

41.5.Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг улсын хилээр нэвтрүүлэх болон тээвэрлэх, хуваарилах, зохион байгуулахтай холбогдсон заавар, удирдамж, төлөвлөгөөг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн холбогдох асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

41.6.Тусламж үзүүлэгч тал дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

41.6.1.иргэдийг үндэс, угсаа, нас, хүйс, шашин шүтлэг, нийгмийн давхарга, гарал, байдал, жендер, хөгжлийн бэрхшээл болон үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах;

41.6.2.нэрвэгдэгсдийн хувийн нууцыг задруулах;

41.6.3.гамшгаас хамгаалах арга хэмжээтэй холбогдолгүй дотоодын асуудалд оролцох, тодорхой улс төрийн болон шашин шүтлэгийн байр суурийг илэрхийлэх;

41.6.4.санхүүгийн ашиг, сонирхол хайх;

41.6.5.хүмүүнлэгийн тусламжтай хамааралгүй асуудлаар мэдээлэл цуглуулах;

41.6.6.гадаад улсын байгууллага болон Засгийн газрын бодлогыг тулгах.

41.7.Тусламж үзүүлэгч талын бараа, үйлчилгээ нь нэрвэгдэгсдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, олон улсад баримталдаг хүмүүнлэгийн бүлэг, хүмүүнлэгийн тусламжийн стандартын хэмжээг хангасан байх ба Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн байна.

41.8.Тусламж үзүүлэгч тал нь бараа, үйлчилгээ болон тоног төхөөрөмжийг гамшгаас хамгаалах арга хэмжээнд ашиглахгүй болох, аюултай хог, хаягдал үүсгэх тохиолдолд дахин боловсруулан ашиглах, эсхүл байгаль орчинд ээлтэй аргаар устгах ажиллагааг өөрийн зардлаар гүйцэтгэнэ.

41.9.Тусламж үзүүлэгч тал олон улсын хүмүүнлэгийн тусламжийг мөнгөн хөрөнгөөр үзүүлэх бол хүлээн авах эсэх асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

41.10.Тусламж үзүүлэгч талын үйл ажиллагаанд онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

41.11.Тусламж үзүүлэгч тал олон улсын хүмүүнлэгийн тусламж үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд хийсэн ажлаа Засгийн газар болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тайлагнана.

42 дугаар зүйл.Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг зогсоох

42.1.Гамшгийн хор уршиг, гамшгийн аюулын учруулах нөлөөлөл буурсан, сэргээн босгох анхан шатны үйл ажиллагааг хэрэгжүүлж дууссан, гамшгийн олон

улсын хүмүүнлэгийн тусламж авах хэрэгцээ хангагдсан гэж үзвэл Засгийн газар тусламж үзүүлэгч талын үйл ажиллагааг зогсоох өдрийг товлону.

42.2.Засгийн газар олон улсын хүмүүнлэгийн үйл ажиллагааг зогсоох өдрийг тусламж үзүүлэгч талд 30 өдрийн өмнө зарлана.

42.3.Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг зогсоосноос үүдэн гарч болох сөрөг үр дагаврыг бууруулах, хариуцлагыг шилжүүлэн өгөх ажиллагааг Засгийн газар тусламж үзүүлэгч талтай зөвшилцөж зохион байгуулна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ АЛБА ХААГЧ

43 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллага, түүний тогтолцоо

43.1.Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах төрийн бодлого, гамшгаас хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах арга хэмжээг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага байна.

43.2.Онцгой байдлын байгууллага мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.

43.3.Онцгой байдлын байгууллага нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, төв, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллага, тэдгээрийн харьяа нэгжээс бүрдэнэ.

43.4.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гамшгаас хамгаалах арга хэмжээг шуурхай зохион байгуулах чиг үүрэг бүхий штабтай байна. Штабын ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

43.5.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяа нэгжийг засаг захиргаа, нутаг дэвсгэр, хүн амын нягтрал, нийгмийн хэрэгцээ шаардлага, гамшгийн нөхцөл байдлыг харгалзан Засгийн газрын шийдвэрээр байгуулна.

43.6.Онцгой байдлын байгууллага олон улсын аврах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх аврах багтай байна.

43.7.Олон улсын аврах ажиллагаанд оролцох алба хаагчийг сонгон шалгаруулах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

44 дүгээр зүйл. Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэдэл

44.1.Онцгой байдлын байгууллага нь туг, бэлгэдэлтэй байна.

44.2.Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэдлийн загварыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

44.3.Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэдэлтэй ижил загварын туг, бэлгэдлийг тус байгууллагаас бусад төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэн хэрэглэхийг хориглоно.

45 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын үндсэн чиг үүрэг

45.1.Онцгой байдлын байгууллага нь дараахь үндсэн чиг үүрэгтэй:

- 45.1.1.гамшгаас урьдчилан сэргийлэх;
- 45.1.2.эрэн хайх, аврах;
- 45.1.3.гамшгийн хор уршгийг арилгах;
- 45.1.4.сэргээн босгох.

46 дугаар зүйл.Онцгой байдлын байгууллагын алба хаагч

46.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагчаар Төрийн албаны тухай хуульд заасан шаардлага, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тогтоосон журам, эрүүл мэнд, бие бялдар, мэргэжил, боловсролын болон ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан иргэнийг авч ажиллуулна.

47 дугаар зүйл.Алба хаагчийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдэг

47.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч нь дүрэмт хувцас, цэргийн цол болон ялгах тэмдэг хэрэглэнэ.

47.2.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргад цэргийн дээд цол олгож болно.

47.3.Цол олгох журам болон дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг Засгийн газар тогтооно.

47.4.Онцгой байдлын байгууллагад алба хаах журам, хувийн дугаар бүхий офицер, ахлагчийн таних тэмдгийн загвар, хэрэглэх журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

48 дугаар зүйл.Алба хаагчийн эрх

48.1.Алба хаагч нь Төрийн албаны тухай, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан нийтлэг эрхээс гадна дараахь эрхийг эдэлнэ:

48.1.1.гамшгийн аюулын болон сургалт, дадлагад оролцох, жижүүрийн үүрэг гүйцэтгэх үедээ хоол, хүнс, тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдах;

48.1.2.гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгахын тулд шаардлагатай объектод саадгүй нэвтрэх;

48.1.3.эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд оролцох үедээ бэртэж гэмтсэн, өвчилсөн тохиолдолд эмнэлгийн тусламж үйлчилгээний төлбөрийг төрөөс төлөх;

48.1.4.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу галт зэвсэг хэрэглэх.

48.2.Онцгой байдлын алба хаагчаар хуульд заасан чиг үүргээс өөр ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

49 дүгээр зүйл.Алба хаагчийн үүрэг

49.1.Алба хаагч нь Төрийн албаны тухай, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан нийтлэг үүргээс гадна дараахь үүргийг хүлээнэ:

49.1.1.гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах, оролцох;

49.1.2.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцохдоо аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг чанд сахих, байгууллага, албан тушаалтан, иргэнд мэргэжлийн чиглэлээр зааварчилгаа өгч, туслалцаа үзүүлэх;

49.1.3.хариуцсан техник, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах.

50 дугаар зүйл.Алба хаагчид олгох нөхөн олговор

50.1.Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч албан үүргээ гүйцэтгэж явахдаа хот, суурингийн доторх нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчино.

50.2.Алба хаагчийн алба хаах хугацааны эрүүл мэндийн оношилгоо, шинжилгээнд хамруулахтай холбогдон гарах зардлыг төр хариуцна.

50.3.Алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд гэр бүлийн нэг гишүүнд алба хаагчийн сүүлд авч байсан нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг 10 жилийн туршид сар бүр олгоно.

50.4.Энэ хуулийн 50.3-т заасан тэтгэмж авах эрх бүхий гэр бүлийн гишүүний дарааллыг дараах байдлаар тогтооно:

50.4.1.тухайн алба хаагчтай гэрлэлтээ бүртгүүлсэн эхнэр /нөхөр/;

50.4.2.тухайн алба хаагчийн төрсөн болон үрчилсэн насанд хүрээгүй хүүхэд;

50.4.3. тухайн алба хаагчтай хамт амьдарч асрамжид нь байсан эцэг, эх, насанд хүрээгүй дүү;

50.4.4.тухайн алба хаагчийн бүрэн асрамжид байсан хөгжлийн бэрхшээлтэй төрсөн ах, эгч, дүү.

51 дүгээр зүйл.Алба хаагчийн баталгаа

51.1.Алба хаагч ажлын бус цагаар хуульд заасан чиг үүргийн дагуу хууль ёсны үйл ажиллагаа явуулсан, түүнчлэн ажилдаа ирэх, буцахыг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцно.

51.2.Алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг байгууллага, албан тушаалтан, иргэн заавал биелүүлэх үүрэгтэй.

51.3. Алба хаагчийн алба хаасан хугацааг тогтооход ажилласан нэг жилийг нэг жил дөрвөн сард дүйцүүлэн тооцно.

51.4.Гамшгийн голомтод ажилласан алба хаагчийн албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно.

51.5.Цэргийн жинхэнэ алба хаасан, цэргийн болон онцгой байдлын байгууллагын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх сургуульд суралцсан хугацааг онцгой байдлын байгууллагад ажилласан хугацаанд оруулан тооцно.

51.6.Албан үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс алба хаагч болон бусдын эд хөрөнгөд учирсан хохирлыг төр хариуцна.

51.7.Алба хаагч цацраг идэвхит, химийн хортой болон аюултай бодис, далд уурхай, усны ослын үед ажилласан тохиолдолд хордлого тайлах болон сэтгэл зүй, бие бялдрын нөхөн сэргээх, сувилах үйлчилгээнд хамрагдана.

51.8.Алба хаагчид онцгой гавъяа байгуулсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн урамшуулал олгож болно.

51.9.Алба хаагчид амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэвэл мөнгөн урамшуулал олгоно. Мөнгөн урамшуулал олгох журмыг Сангийн болон Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан тушаалаар батална.

52 дугаар зүйл.Аврагч

52.1.Мэргэжлийн тусгай сургалтад хамрагдаж, аврах ажиллагааны арга, технологи эзэмшсэн алба хаагчийг аврагчаар томилно.

52.2.Аврагч нь мэргэшлийн зэрэгтэй байна.

52.3.Аврагчийн мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална.

52.4.Аврагч үүргээ гүйцэтгэх үедээ аврах ажлын тусгай зориулалтын хувцас, хэрэгсэл, иж бүрдлээр хангагдана.

52.5.Аврах ажлын тусгай зориулалтын хувцас, хэрэгсэл, иж бүрдлийн жагсаалт, түүнийг бүртгэх, ашиглах, хадгалах, хамгаалах, олгох журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

АРАВДУГААР БҮЛЭГ ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ

53 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт

53.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвийн багцдаа гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, шаардагдах хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу батлуулна.

53.2.Байгууллага, хуулийн этгээд өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тухайн жилийнхээ төсвийн 5 хүртэлх хувийг төлөвлөж зарцуулна.

53.3.Аймаг, нийслэл, сум дүүрэг нь тухайн жилийн батлагдсан төсвийн 2 хувийг орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах санд тусгаж, гамшгаас хамгаалах арга хэмжээнд зарцуулна.

53.4.Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах төвлөрсөн арга хэмжээний зардлыг улсын төсвөөс, аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах арга

хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, байгууллага, хуулийн этгээд зардлаа өөрөө хариуцна.

53.5.Гамшгийн эрсдэлийг бууруулах судалгаа, шинжилгээ, төлөвлөлтийг оновчтой хийсэн, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж эрсдэлийг бодитой бууруулсан, байгууллага, хуулийн этгээд, албан тушаалтан, иргэнийг шагнаж урамшуулах зардлыг гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн сангаас гаргана.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

54 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

54.1.Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч дараах захиргааны шийтгэл ногдуулна:

54.1.1.энэ хуулийн 34.1, 35.2, 38.2-д заасныг зөрчсөн иргэнийг 100,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 1,000,000 төгрөгөөр торгох;

54.1.2.энэ хуулийн 9.1, 11.3-11.5, 14.3, 17.3, 19.4, 33.1.1, 33.1.3, 33.1.8, 33.1.10-33.1.12-т заасныг зөрчсөн иргэнийг 500,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 5,000,000 төгрөгөөр торгох.

ГАРЫН ҮСЭГ